

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/05/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.15 № 01/34
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.7 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/04 тоот тушаалыг тус тус үндэслэн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал"-аар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 7,947.2 мянган төгрөг буюу татаас санхүүжилтийн авлагаар нэмэгдсэн байна.
- Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 4,300.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 800.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 39,627.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,100,788.00	63,943,497.17
33	АВЛАГА	0	7,947,200.17
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0	7,947,200.17
35	БАРАА МАТЕРИАЛ	52,100,788.00	55,996,297.00
35400	Хангамжийн материал	52,100,788.00	55,996,297.00
35410	Бичиг хэргийн материал	6,772,150.00	9,355,550.00
35420	Аж ахуйн материал	30,329,540.00	31,621,649.00
35470	Бусад хангамжийн материал	14,999,098.00	15,019,098.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,094,143,853.00	1,052,562,191.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,094,143,853.00	1,052,562,191.00
39200	Биет хөрөнгө	1,058,314,886.44	1,017,037,191.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,066,793,912.00	1,066,793,912.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70,909,656.40	-89,582,028.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,000,000.00	50,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,000,000.00	-50,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	189,921,463.57	159,828,858.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,921,714.82	-125,899,897.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,460,820.90	53,890,258.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-54,192,818.89	-47,993,912.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	488,640.00	488,640.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-325,759.92	-488,640.00
39300	Биет бус хөрөнгө	35,828,966.56	35,525,000.00
39301	Програм хангамж	911,900.00	911,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-607,933.44	-911,900.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,525,000.00	35,525,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,146,244,641.00	1,116,505,688.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,146,244,641.00	1,116,505,688.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,146,244,641.00	1,116,505,688.17
51100	Засгийн газрын оруулсан капитал	337,312,636.93	337,312,636.93
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	337,312,636.93	337,312,636.93
51200	Хуримтлагдсан үр дүн	699,221,450.92	701,723,507.25
51210	Өмнөх үеийн үр дүн	760,543,797.55	731,462,460.08
51220	Тайлант үеийн үр дүн	-61,322,346.63	-29,738,952.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,710,553.15	77,469,543.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,146,244,641.00	1,116,505,688.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,029,687,926.96	1,644,660,431.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,698,376.96	198,707,281.68
120	Нийтлэг татварын бус орлого	164,698,376.96	198,707,281.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	161,586,000.00	185,079,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,586,000.00	185,079,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,112,376.96	13,577,781.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,989,550.00	1,445,953,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	788,878,300.00	1,282,868,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	788,878,300.00	1,282,868,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,111,250.00	163,084,850.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28,211,250.00	28,603,155.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	57,991,935.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,100,000.00	76,489,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,091,010,273.59	1,671,115,891.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,010,273.59	1,671,115,891.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,032,049,314.78	1,501,769,449.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,108,797.05	1,040,953,044.80
210101	Үндсэн цалин	503,184,579.82	601,565,727.79
210102	Нэмэгдэл	107,534,568.43	257,930,424.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,508,000.00	112,810,000.00
210104	Урамшуулал	23,881,648.80	68,646,892.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,198,417.14	130,467,726.94
210201	Тэтгэврийн даатгал	55,261,495.74	86,514,111.92
210202	Тэтгэмжийн даатгал	6,913,724.50	10,968,032.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,886,574.17	12,425,139.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,092,714.26	1,840,652.49
210205	Эрүүл мэндийн даатгал	11,043,908.47	18,719,791.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,332,097.00	102,893,588.67
210301	Гэрэл, цахилгаан	45,285,456.00	59,121,733.39
210302	Түлш, халаалт	29,224,800.00	39,750,189.28
210303	Цэвэр, бохир ус	2,821,841.00	4,021,666.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,817,155.00	29,545,861.00
210401	Бичиг хэрэг	5,988,150.00	6,161,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,692,350.00	10,748,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,890.00	1,726,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	253,200.00	504,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,342,565.00	10,404,911.00
2105	Нормативт зардал	63,548,069.00	66,840,849.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	381,360.00	558,650.00
210502	Хоол, хүнс	63,166,709.00	66,282,199.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,097,000.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,097,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	5,182,000.00	3,008,000.00
210702	Дотоод албан томилолт	5,182,000.00	3,008,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,724,656.00	66,764,428.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,449,254.00	64,338,078.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,344,800.00	1,329,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429,000.00	533,000.00
210807	Газрын төлбөр	349,352.00	411,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,041,123.59	61,295,950.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	4,320,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,041,123.59	56,975,950.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,960,958.81	169,346,441.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,792,100.00	450,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,982,100.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,123,208.81	168,896,441.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,123,208.81	135,816,094.65
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	33,080,347.17
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,045,650.00	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,045,650.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-61,322,346.63	-26,455,459.63
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	3,283,493.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	3,283,493.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-61,322,346.63	-29,738,952.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,575,550.00	1,631,032,650.00		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,586,000.00	185,079,500.00		
120	Нийтлэг татварын бус орлого	161,586,000.00	185,079,500.00		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	161,586,000.00	185,079,500.00		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,586,000.00	185,079,500.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,989,550.00	1,445,953,150.00		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	788,878,300.00	1,282,868,300.00		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	788,878,300.00	1,282,868,300.00		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,111,250.00	163,084,850.00		
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	28,211,250.00	28,603,155.00		
131103	ЗГНХ ЭДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00	57,991,935.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,100,000.00	76,489,760.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00	0		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,025,106,650.00	1,625,932,650.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,025,106,650.00	1,625,932,650.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	966,145,691.19	1,448,339,008.01		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,955,720.05	964,384,493.25		
210101	Үндсэн цалин	441,888,378.57	520,361,631.79		
210102	Нэмэгдэл	106,528,119.95	256,728,240.02		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,657,572.73	111,228,152.01		
210104	Урамшуулал	23,881,648.80	76,066,469.43		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,705,374.68	129,904,636.10		
210201	Тэтгэврийн даатгал	50,937,347.55	87,976,553.64		
210202	Тэтгэмжийн даатгал	5,960,881.58	10,829,239.67		
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,748,605.53	11,195,003.24		
210204	Ажилгүйдлийн даатгал	1,187,176.39	1,809,004.76		
210205	Эрүүл мэндийн даатгал	11,871,363.63	18,094,834.79		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,332,097.00	100,913,588.67		
210301	Гэрэл, цахилгаан	45,285,456.00	59,121,733.39		
210302	Түлш, халаалт	29,224,800.00	39,750,189.28		
210303	Цэвэр, бохир ус	2,821,841.00	2,041,666.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	13,403,940.00	26,266,839.00		
210401	Бичиг хэрэг	5,602,200.00	6,108,750.00		
210402	Тээвэр, шатахуун	3,542,350.00	10,748,240.00		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,890.00	1,726,760.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	253,200.00	504,100.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,465,300.00	7,178,989.00		
2105	Нормативт зардал	66,148,784.00	68,179,630.60		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	381,360.00	558,650.00		
210502	Хоол, хүнс	63,193,109.00	64,535,049.60		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,574,315.00	3,085,931.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,047,000.00	1,679,050.00		
210601	Багаж, техник, хэрэгсэл	992,000.00	1,046,000.00		
210604	Урсгал засвар	55,000.00	633,050.00		
2107	Томилолт, зочны зардал	5,182,000.00	3,008,000.00		
210702	Дотоод албан томилолт	5,182,000.00	3,008,000.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,370,775.46	147,127,570.39		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	132,095,373.46	144,881,220.39		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,344,800.00	1,149,200.00		
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429,000.00	533,000.00		
210807	Газрын төлбөр	349,352.00	411,900.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	6,875,200.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	6,875,200.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,960,958.81	177,593,641.99		
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,792,100.00	750,000.00		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,982,100.00	0		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	750,000.00		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,123,208.81	176,843,641.99		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,123,208.81	143,763,294.82		
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	33,080,347.17		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,045,650.00	0		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,045,650.00	0		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,468,900.00	5,100,000.00		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,468,900.00	5,100,000.00		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,468,900.00	5,100,000.00		
2200	Дотоод эх үүсвэрээр	1,468,900.00	5,100,000.00		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,468,900.00	5,100,000.00		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,468,900.00	-5,100,000.00		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	1,207,566,987.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	1,207,566,987.63
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-61,322,346.63	-61,322,346.63
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	699,221,450.92	1,146,244,641.00
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	699,221,450.92	1,146,244,641.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	32,241,009.16	32,241,009.16
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	731,462,460.08	1,178,485,650.16
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-32,241,009.16	0	-32,241,009.16
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-29,738,952.83	-29,738,952.83
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	337,312,636.93	77,469,543.99	701,723,507.25	1,116,505,688.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/ төгрөгөөр / Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,460,068,300.00	1,324,184,505.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,460,068,300.00	1,324,184,505.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,458,598,000.00	1,323,434,505.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,045,848,200.00	926,501,709.74
210101	Үндсэн цалин	624,424,100.00	520,361,631.79
210102	Нэмэгдэл	362,599,900.00	218,845,456.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,819,600.00	111,228,152.01
210104	Урамшуулал	36,004,600.00	76,066,469.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,356,100.00	126,095,920.10
210201	Тэтгэврийн даатгал	90,002,100.00	85,444,315.64
210202	Тэтгэмжийн даатгал	10,588,500.00	10,521,917.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,470,800.00	10,608,564.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,117,700.00	1,749,379.96
210205	Эрүүл мэндийн даатгал	21,177,000.00	17,771,741.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,537,800.00	95,326,083.35
210301	Гэрэл, цахилгаан	23,330,300.00	58,942,433.39
210302	Түлш, халаалт	66,881,700.00	34,341,983.96
210303	Цэвэр, бохир ус	6,325,800.00	2,041,666.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,532,000.00	10,235,619.00
210401	Бичиг хэрэг	277,600.00	274,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,620,600.00	1,608,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,054,000.00	813,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	504,100.00	504,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,075,700.00	7,035,509.00
2105	Нормативт зардал	69,175,000.00	66,492,130.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	560,000.00	558,650.00
210502	Хоол, хүнс	65,500,000.00	62,847,549.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,115,000.00	3,085,931.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,827,000.00	6,779,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,193,400.00	6,146,000.00
210604	Урсгал засвар	633,600.00	633,050.00
2107	Томилолт, зочны зардал	200	0
210702	Дотоод албан томилолт	200	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,321,700.00	92,003,992.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,860,000.00	89,757,642.39
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,149,200.00	1,149,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	159,500.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,200.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,600.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	533,300.00	533,000.00
210807	Газрын төлбөр	411,900.00	411,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,470,300.00	750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,470,300.00	750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,300.00	750,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,460,068,300.00	1,339,903,352.19
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,282,868,300.00	1,154,823,852.19
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,282,868,300.00	1,154,823,852.19
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	177,200,000.00	185,079,500.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,200,000.00	185,079,500.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	111	111
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55	55
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	45	45
620003	Үйлчлэх ажилтан	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	55
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	46	46
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	163,084,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,084,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	130,004,502.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,882,783.51
210102	Нэмэгдэл	37,882,783.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,808,716.00
210201	Тэтгэврийн даатгал	2,532,238.00
210202	Тэтгэмжийн даатгал	307,322.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	586,438.40
210204	Ажилгүйдлийн даатгал	59,624.80
210205	Эрүүл мэндийн даатгал	323,092.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,587,505.32
210301	Гэрэл, цахилгаан	179,300.00
210302	Тулш, халаалт	5,408,205.32
2104	Хангамж, бараа материалын зардал	16,031,220.00
210401	Бичиг хэрэг	5,834,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,140,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	143,480.00
2105	Нормативт зардал	1,687,500.00
210502	Хоол, хүнс	1,687,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,008,000.00
210702	Дотоод албан томилолт	3,008,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,123,578.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,123,578.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,875,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,875,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,080,347.17
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	163,084,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,084,850.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	28,603,155.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,991,935.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,489,760.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сан, Захиргаа хяналтын хэлтэс гэсэн 3 нэгж, 55 орон тоо батлагдсанаас 46 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлаг байна.

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.7 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/04 тоот тушаалыг тус тус үндэслэн “Орлогыг орлуулан тооцог аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод, хүний нөөцийн, төсөв, санхүүгийн ил тод байдлыг тогтмол хангах хүрээнд Веб хуудас болох <http://tov.hudulmur-halamj.gov.mn/>, Facebook хаяг /Төв аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/, Нээлттэй утас 7720-1220, мэдээллийн самбар, орон нутгийн телевизүүд, Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах албаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан байна.

Тус газар нь тайлант онд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тусгагдсан 5 зорилт 60 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 93,0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2, 6, 2,12, 23, 29 дүгээр заалтуудад тус тус өөрчлөлт орсон.
- 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр"-ийг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023

оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/09 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 15 арга хэмжээтэй боловсруулж газрын болон сумдын мэргэжилтэн нарт 6 удаагийн зөвлөмж чиглэлийг цахимаар болон цаасан хэлбэрээр өгч ажилласан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн "Хяналт шалгалтын нэгдсэн удирдамж хүргүүлэх тухай" 05/583 тоот албан бичиг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2021 оны А/103 тушаалаар батлагдсан хүнсний эрхийн бичиг олгох журмын хүрээнд 27 сумын 2017-2022 онуудад хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан 1,839 өрхийн хувийн хэрэгт тооллого хийж, 2023 онд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 358 өрхийн хувийн хэргийн анхан шатны баримт бүрдэлтэд хяналт шалгалтыг хийсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн №А/174 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 5 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,739.0 мянган төгрөгөөр буюу 2,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	7,947.2	7,947.2
Урьдчилгаа			
Бараа материал	52,100.8	55,996.3	3,895.5
Үндсэн хөрөнгө	1,094,143.9	1,052,562.2	(41,581.7)
Нийт хөрөнгө	1,146,244.6	1,116,505.7	(29,739.0)
Өр төлбөр	35,829.0	35,525.0	(304.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,146,244.6	1,116,505.7	(29,739.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,146,244.6	1,116,505.7	(29,739.0)

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 7,947.2 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлагаар нэмэгдсэн байна. Энэ нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Аз жаргалын өргөөний санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс үүссэн авлага байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 52,100.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 55,996.3 мянган төгрөг, 3,895.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,094,143.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,052,562.2 мянган төгрөг буюу 88,290.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 4,300.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 800.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 39,627.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,116,505.7 мянган төгрөг болж 29,739.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,208,393.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газраас төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,461.8 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс санхүүжүүлэх төсвийг 978,387.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 147,200.0 мянган төгрөг нийт 1,117,931.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын төсвийг 2023 оны 7 дугаар сард Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 164,936.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 1,282,868.3 мянган төгрөгөөр, 30,000.0 мянган төгрөгөөр үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэн 177,200.0 мянган төгрөг нийт 1,460,068.3 мянган төгрөгөөр тодотгон ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,282,868.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, үйл ажиллагааны орлогыг 177,200.0 мянган төгрөгөөр нийт 1,460,068.3 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,282,868,3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 185,079.5 мянган төгрөгийг бүрдүүлж, төсвөөс 135,883.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,879.5 мянган төгрөг нийт 143,763.3 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,324,184.5 мянган төгрөг буюу 90,9 хувьтай байгаа нь цалин, НДШ 125,606.7 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 1,211.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 293.4 мянган төгрөг, норматив зардал 2,682.9 мянган төгрөг, эд хогшил авах зардал 48.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 6,317.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 720.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,879.5 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нийгмийн халамж-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,118,300.8	1,005,274.2	113,026.6	89,9
2	Нийгмийн халамж-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	177,200.0	169,360.7	7,839.3	95,6
3	Нийгмийн халамж-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,470.3	750.0	720.3	51,0
4	Нийгмийн халамж-Үндсэн үйл ажиллагааны зардал	163,097.2	148,799.7	14,297.5	91,2
	Дүн	1,460,068.30	1,324,184.5	135,883.7	90,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансанд “ХОЛТ” олон улсын байгууллагын хүүхдийн амьжиргааг дэмжих төслөөс 28,603.2

мянган төгрөг, дээд шатны захирагчаас 57,991.9 мянган төгрөг, Амьжиргаа дэмжих зөвлөлөөс 89,153.8 мянган төгрөг, нийт 175,748.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар цалин, НДШ зардалд 41,691.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 5,587.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16,031.2 мянган төгрөг, норматив зардалд 1,687.5 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 3,008.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 55,123.6 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардалд 6,875.2 мянган төгрөг нийт 130,004.5 мянган төгрөг зарцуулж 45,744.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 33,080.3 мянган төгрөгийг улсын төсөвт, хөдөлмөр аюулгүй байдлын сургалтын 256.0 мянган төгрөгийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвд, орлогыг орлуулан тооцож өрхийн амьжиргааны түвшин тогтоох өрхийн судалгааны зардал 12,216.0 мянган төгрөгийг Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөлд, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний 192.0 мянган төгрөгийг даатгалын санд тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Нийгмийн халамж-71902	2022.01.01 2022.12.31	Нийгмийн халамжийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын хэрэгжилтийг хангах, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид шинээр хамрагдсан болон сунгуулсан иргэдийн мөнгийг програмын түвшинд хянан баталгаажуулж олгох	НХСангийн хэрэгжилт 90,6%	1,296,971.1	1,175,384.8
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих-72102	2022.01.01 2022.12.31	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 91,6%	163,097.2	148,799.7

Төв аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь батлагдсан төсвийг зарцуулж хөтөлбөрийн хэрэгжилт 90,9%-тай, 9 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ зардлаас 125,606.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, ажлын байрыг зарласан ч хүн ирээгүйгээс шалтгаалжээ.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 96,537.8 мянган төгрөгийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар, 22,991.6 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, тендер шалгаруулалтаар 52,500.0 мянган төгрөгийн хоол, хүнсний материал нийт 185,029.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан

авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 114,641,5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын даргын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 88 тоот албан бичгээр ахмадын амралтын хоолны 52,500.0 мянган төгрөгийг тендер зарлах хүсэлтийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн ч 4 удаагийн тендер шалгаруулалт явуулахад оролцогч оролцоогүй байна. Тайланд онд тендерт шалгарсан оролцогч гараагүйгээс Од супер маркет, Эрдэнэ хүнс ХХК, Юмт шимт арго ХХК зэрэг аж ахуй нэгж байгууллагуудтай шууд гэрээ байгуулан Ахмадын амралтын хүнсний материалын худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2023 оны батлагдсан төсвийн 1,118,300.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 13,774.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,742.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100%-тай, 5,0 саяас дээших орлогын 51 гүйлгээ, зарлагын 8 гүйлгээг мэдээлснээс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл 3 байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 223 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	445,426.5	1	445,426.5	100
Нийт дүн	1	445,426.5	1	445,426.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 104,463.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 5,208.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 99,255.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд бичиг хэргийн зардлыг хэмнээгүй 5,208.0 мянган төгрөгөөр бичгийн цаас, принтерийн хор их хэмжээгээр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

•Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Нягтлан бодох бүртгэл холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд бараа материалын НХМ-БМ9 маягтыг хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайлан НХМ-БМ9 маягтыг хөтөлж хэвших.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд Чиглэл тоног төхөөрөмж ХХК-аас 4,300.0 мянган төгрөг, Рич хангай ХХК-аас 800,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус худалдан авсан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрийн бараанаас худалдан авалт хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Няравын гаргасан тайланг шалгахад НХМ-БМ9 маягтыг хөтөлөөгүй байна.	1	94,155.8					1	94,155.8
Чиглэл тоног төхөөрөмж ХХК-аас 4300,0 мянган төгрөг, Рич хангай ХХК-аас 800,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус худалдан авсан байна.	1	5,100.0					1	5,100.0
Бичгийн цаас, принтерийн хор, бичгийн хавтас их хэмжээгээр худалдан авалтыг хийсэн байна	1	5,208.0			1	5,208.0		
Дүн	1	104,463.8			1	5,208.0	1	99,255.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn